

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

Сэдэв: “Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх”

Зохион байгуулсан огноо:

2026 оны 06 дугаар сарын 23, 24-ний өдрүүд

Төрийн ордон-“Их Эзэн Чингис хаан” танхим

Агуулга

Агуулга.....	1
1. Сонсгол зохион байгуулсан үндэслэл.....	3
2. Оролцогчдын мэдээлэл.....	4
3. Сонсголын явц.....	5
4. Танилцуулга, мэдээллүүд.....	6
5. Иргэдийн санал	8
6. УИХ-ын гишүүдийн асуулт, хариулт	10
7. Гишүүдийн байр суурь.....	11
8. Сонсгол даргалагчийн дүгнэлт.....	13
9. Нэгдсэн дүгнэлт	13
10. Цаашид авах арга хэмжээний санал.....	14

1. Сонсгол зохион байгуулсан үндэслэл

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тулгуур салбарын нэг болсон мал аж ахуйн салбарыг дэмжих үүднээс Малчны тухай хууль (анхдагч)-ийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр УИХ баталж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн боловч хэрэгжилт хангалтгүй, хуулийг дагалдан гарах ёстой журмуудын дийлэнх нь батлагдаагүй, салбар хоорондын уялдаа хангагдаагүй, хуулийг сурталчлах ажлыг Засгийн газар хэрэгжүүлээгүй байна.

Иймд хуулийн хэрэгжилтийг нэхэн шаардах, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгээс 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-03/5687 дугаар албан бичгээр ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын даргад хандаж гаргасан. Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулахыг дэмжиж Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, О.Амгаланбаатар, Д.Батбаяр, Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Г.Ганбаатар, Д.Ганбат, М.Ганхүлэг, Б.Заяабал, С.Лүндэг, Л.Мөнхбаатар, Н.Наранбаатар, У.Отгонбаяр, Р.Сэддорж, Ц.Туваан, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, Г.Хосбаяр, Дав.Цогтбаатар, Р.Эрдэнэбүрэн нарын 20 гишүүн гарын үсэг зурсан байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т зааснаар Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд Улсын Их Хурлын Ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу заавал явуулах бөгөөд энэ дагуу Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн "Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай" 05 дугаар тогтоолоор "Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх" сэдвээр Ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулахаар тогтож сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнийг томилсон. Мөн сонсголын бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг тус Байнгын хорооны 06 дугаар тогтоолоор баталсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, гишүүдэд УИХ-ын гишүүн Д.Батбаяр, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Замира, Л.Мөнхбаясгалан, У.Отгонбаяр, Р.Сэддорж, Ц.Туваан, Г.Тэмүүлэн нар ажиллав.

Ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд Төрийн ордны "Их Эзэн Чингис хаан" танхимд нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, Малчин телевиз болон Улсын Их Хурлын цахим сувгаар шууд дамжуулан олон нийтэд хүргэсэн бөгөөд сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах боломжийг хангах зорилгоор дохионы хэлний орчуулгыг зэрэг хүргэж ажилласан нь төрийн үйл ажиллагааны ил тод байдал, иргэдийн мэдэх эрхийг хангах, парламентын хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болсон юм.

Сонсголоор мэдээлэл сонсох, цуглуулах, төрийн болон төрийн бус байгууллага, малчдын мэдэх эрхийг хангах, саналыг сонсох, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах зорилго тавьж ажиллав.

Ерөнхий хяналтын сонсголын хүрээнд төрийн байгууллагуудын тайлагнал, судалгааны үр дүн, Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хариулт, малчдын санал, байр суурийг нэгтгэн үзэхэд Малчны тухай хууль хэрэгжиж эхэлсэн хугацаанд тодорхой ахиц гарсан хэдий ч хуулиар Засгийн газар болон холбогдох байгууллагад хүлээлгэсэн зарим үүргийн хэрэгжилт хангалтгүй, салбар хоорондын уялдаа сул, зарим журам, аргачлал батлагдаагүй, санхүүжилт болон хэрэгжилтийн зохион байгуулалт жигд бус байгаа нь сонсголын үеэр нийтлэгээр хөндөгдөв.

Илтгэл бүрийн дараа Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, холбогдох байгууллагын удирдах албан тушаалтнууд хариулт өгч, сонсголд оролцсон малчид, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл нийт давхардсан тоогоор 50 удаа санал, тайлбар хэлж, Малчны тухай хуулийн хэрэгжилтийн явцад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх шаардлагатай эрх зүйн болон бодлогын асуудлыг хөндөн тавьсан.

Энэхүү тайланд Ерөнхий хяналтын сонсголын үеэр танилцуулсан илтгэлүүд, Малчны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний судалгааны үр дүн, Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хариулт, хэлэлцүүлэг, малчид, иргэдийн санал, байр суурийг нэгтгэн шинжилж, Малчны тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн санал, дүгнэлтийг боловсруулав.

2. Оролцогчдын мэдээлэл

“Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сэдвээр Ерөнхий хяналтын сонсголын зарыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2-т “...сонсгол явуулах сэдэв, огноо, оролцогч, ажиглагчийг бүртгэх зарыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулна...” гэж заасны дагуу 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр www.parliament.mn цахим хуудаст байршуулсан.

Оролцогчдыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.11-д заасны дагуу “...14-өөс доошгүй хоногийн хугацаанд бүртгэнэ...” гэж заасны дагуу 06 дугаар сарын 18-ны өдрийн 17.00 цаг хүртэл бүртгэлээ.

Ерөнхий хяналтын сонсголын эхний өдөр төрийн байгууллагын төлөөллийн ирц 79.2 хувь (42/53), иргэдийн төлөөллийн ирц 68.7 хувь (46/67) буюу нийт 88 хүн оролцсон бөгөөд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүдийн ирц 51.7 хувь

(15/29)-тай байв. Сонголыг 09:00 цагт эхлүүлэхээр товлосон боловч Байнгын хорооны ирц бүрдсэнээр 09 цаг 34 минутад эхлүүлэв.

Сонголын хоёр дахь өдөр төрийн байгууллагын төлөөллийн ирц 53.3 хувь (32/60), иргэдийн төлөөллийн ирц 63.2 хувь (43/68) буюу нийт 75 хүн оролцож, Байнгын хорооны гишүүдийн ирц 65.5 хувь (19/29)-д хүрсэн байна. Сонголыг 10:00 цагт эхлүүлэхээр төлөвлөсөн боловч Байнгын хорооны ирц бүрдсэнээр 10 цаг 13 минутад эхлүүлэв.

Мөн сонголд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, судлаачид, сэтгүүлчид болон малчдын төлөөлөл оролцож, санал, шүүмжлэл, байр сууриа илэрхийлсэн бөгөөд иргэдээс ирүүлсэн бичгээр болон цахимаар хүргүүлсэн санал, хүсэлтүүдийг 2 өдрийн сонголын явцад сонголт даргалагч УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулсан.

Оролцлогын тоон үзүүлэлт

Үзүүлэлт	1 дэх өдөр (06.23)	2 дахь өдөр (06.24)
Байнгын хорооны гишүүдийн ирц	51.7% (29-өөс 15 гишүүн)	65.5% (29-өөс 19 гишүүн)
Төрийн байгууллагын төлөөлөл	42	32
Иргэд, ТББ-ын төлөөлөл	46	43
Нийт оролцогч	88	75
Эхэлсэн / дууссан цаг	09:35 – 17:17	10 цагт эхэлсэн

Сонголд Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Архангай, Булган, Хөвсгөл, Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Говь-Алтай, Увс, Завхан, Дундговь зэрэг аймгаас 60 орчим малчин хүрэлцэн ирсэн. Тэдний дунд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Шагдарсүрэн, гавьяат малчин Д.Гомбо-Очир, аварга малчин Р.Мөнхтөр зэрэг хүмүүс байв.

Илтгэл тавьсан төрийн байгууллагууд: Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Сангийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам (ЦХИХХЯ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ), Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Монголбанк, Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС), Мал эмнэлгийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Монголын Хуульчдын Холбоо.

3. Сонголын явц

Сонголт нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан дэг журмын дагуу явагдсан бөгөөд хоёр өдрийн турш ижил бүтэцтэйгээр зохион байгуулагдав:

1. Сонсгол даргалагч нээлтийг зарлаж, ирц, дэг, оролцогчийн эрх, үүрэг (Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 124, 125 дугаар зүйл), сонсголд оролцогчийн хариуцлага (Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24–21.31, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 57 дугаар зүйл)-ийг танилцуулсан.
2. Хөтөлбөрийн дагуу холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан илтгэл, танилцуулга хийсэн.
3. Танилцуулга бүрийн дараа сонсголд оролцогч иргэд 3 минутад багтаан санал, тайлбараа хэлсэн.
4. Улсын Их Хурлын гишүүд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнаас асуулт асууж, хариулт авч, үг хэлсэн.
5. Урьдчилан бичгээр ирүүлсэн санал, хүсэлтийг сонсгол даргалагч уншиж танилцуулан тэмдэглэлд тусгасан.
6. Сонсгол даргалагч дүгнэлт хэлж, сонсголыг хаасан.

Сонсголын эхний өдөр буюу 06 дугаар сарын 23-ны өдөр 7 илтгэл, хоёр дахь өдөр буюу 06 дугаар сарын 24-ний өдөр 5 илтгэл, нийт 12 илтгэлийг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан танилцуулсан болно.

Эхний өдөр Боловсролын, Сангийн, Цахим хөгжлийн, Эрүүл мэндийн сайд нар ирэлгүй төлөөллөө явуулсан; хоёрдугаар өдөр ХХААХҮ-ийн сайд Ц.Идэрбат, ГБХНХ-ын сайд Т.Аубакир нар биечлэн оролцов.

Сонсголд сайд нарын оролцоо хангалтгүй байгаа талаар Улсын Их Хурлын гишүүд шүүмжлэлтэй хандаж, сонсголын үйл ажиллагаа түр зогсоох санал гарсан.

4. Танилцуулга, мэдээллүүд

Сонсголд танилцуулагдсан 12 илтгэлийг дараах байдлаар нэгтгэв.

№	Сэдэв	Илтгэгч
1	Малчны тухай хуулийн танилцуулга	УИХ-ын гишүүн, хууль санаачлагч Г.Тэмүүлэн
2	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Монголын Хуульчдын Холбооны судлаач О.Энххүслэн
3	Малчны хөгжлийг дэмжих, залгамж халааг бэлтгэх	Боловсролын сайд Л.Энх-Амгалан (илтгэлийг ТНБД Т.Ням-Очир)
4	Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд авсан арга хэмжээ	Сангийн сайд З.Мэндсайхан (илтгэлийг ТНБД Б.Анар)
5	Цахим шилжилтийг малчны үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номин (илтгэлийг ТНБД Б.Мягмарнаран)
6	Малчны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж	Эрүүл мэндийн сайд Э.Батшугар (илтгэлийг ТНБД Н.Эрдэнэбаяр)

№	Сэдэв	Илтгэгч
7	Бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулах зарим асуудал	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай
8	Малчдын санхүүгийн үйлчилгээний хүртээмж, зээл	Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван
9	Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулах	Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян
10	Хуулийн хэрэгжилтийн явц, үр дүн, цаашдын арга хэмжээ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат
11	Малчны хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир
12	Малчны хамтын санаачилга, хоршил — Шинэ хоршоо	Шадар сайд Н.Номтойбаяр (илтгэлийг ШС-ын ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил)

Илтгэлүүдээс гарсан гол тоо баримт, дүгнэлт

Илтгэлд дурдагдсан тоо баримт, дүгнэлтийн талаар:

Хуулийн хэрэгжилтийн үнэлгээ Малчны тухай хууль нь нийт 16 зүйлтэй бөгөөд 80% буюу 12 зүйлд нь дүн шинжилгээ хийхэд: хэрэгжиж буй зохицуулалт 26.7%, сул хэрэгжилттэй 33.3%, огт хэрэгжээгүй 20% байна. Хуулийн 5, 9 дүгээр зүйл хэрэгжиж байгаа; 6, 7, 11, 12, 15 дугаар зүйлийн хэрэгжилт сул; 13 дугаар зүйл (Малчны хөгжлийн сан, индекс), 14 дүгээр зүйл (Малчны хөгжлийн төв), 9.1 (бүтээмж тооцох арга зүй) огт хэрэгжээгүй.

Журмын хэрэгжилт. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газраас батлах журмын хэрэгжилтийн хувьд ХХААХҮЯ, Сангийн яам, ГБХНХЯ-ны танилцуулсан мэдээллээр “Малчны хөгжлийн сангийн журам” болон “Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх журам” батлагдаагүй байна.

Боловсрол. 2025–2026 оны хичээлийн жилд 171,488 малчин өрхийн хүүхэд боловсролын тогтолцоонд хамрагдаж байгаа (нийт суралцагчдын 13.3%). Малчны тухай хуулийн 4.2.5-ын дагуу 10-аас доошгүй жил мал малласан малчны хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлээр төрийн өмчийн их сургуульд үнэ төлбөргүй суралцуулж, 2025–2026 онд 50 оюутанд нийт 56.1 сая төгрөгийн тэтгэлэг олгосон. Гэвч мал эмнэлэг, зоотехникийн мэргэжил хамрагдаагүйгээс хамрах хүрээ хязгаарлагдмал гэсэн шүүмжлэл гарсан.

Санхүүгийн дэмжлэг (Сангийн яам, Монголбанк). Шинэ хоршоо–Чинээлэг малчин хөтөлбөрөөр 894.8 тэрбум төгрөгийн зээлийг 26,437 малчин өрхөд (6%-ийн хүүтэй); Цагаан алт хөтөлбөрөөр 520.7 тэрбум; Хүнсний хангамж, аюулгүй байдлын хөтөлбөрөөр 1.2 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон. Орон нутгийн 3%-ийн хүүтэй ипотекийн зээлд 2023–2025 онд 5,173 өрхөд 536.6 тэрбум төгрөг олгосон ч малчин

хүртэх нь хязгаарлагдмал. Нийгмийн даатгалын шимтгэлийн 50%-ийг төрөөс хариуцаж, 2025 онд 57,900 малчинд ≈29 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн.

Малчны зээл (Монголбанк). Малчдын зээлийн үлдэгдэл 1.1 их наяд төгрөг, нийт 122,838 зээл. Дундаж хүү 22.2% буюу хэрэглээний зээлээс 4.4%, бизнесийн зээлээс 5.9% өндөр; харин чанаргүй зээл дөнгөж 1.8% буюу малчид хамгийн сахилга баттай зээлдэгчдийн нэг. Нэг малчин өрхийн дундаж зээл 8.9 сая төгрөг.

Эрүүл мэнд (ЭМЯ). Малчдын эрүүл мэндийн даатгалын хамрагдалт 40%-д хүрэхгүй; 2024 онд 51,187, 2025 онд 37,387, 2026 оны эхний 5 сард 8,790 малчин даатгалд хамрагдсан буюу буурах хандлагатай. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн ажил 2025 оны 10 дугаар сараас зогссон.

Газар, бэлчээр. Улсын нийт газар нутгийн 85.7% (134.1 сая га) нь ХАА-н газар. Малчны тухай хууль хэрэгжсэн 2 жилд 9,299 байршилд 3,224 га газрыг өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшүүлсэн. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй давхцалтай 1,333, хайгуулын зөвшөөрөлтэй давхцалтай 3,389 нэгж талбар байна. Эзэмшүүлсэн газрын 94% нь эрэгтэй, 6% нь эмэгтэй малчинд олгогдсон.

Гамшгийн эрсдэл (ОБЕГ). Сүүлийн 10 жилд гамшиг, аюулт үзэгдлийн тохиолдол 25% өссөн. 2023–2024 оны зудаар 8.1 сая толгой мал (нийт малын 12.5%) хорогдож, эдийн засагт ≈1.4 их наядын хохирол учирсан. Сүүлийн 5 жилд ус, цаг агаарын аюулт үзэгдлийн улмаас 44 малчин амь насаа алдсан.

Шинэ хоршоо (Шадар сайдын ажлын алба). 10,578 хоршоо байгуулагдаж, 103,340 малчин гишүүнээр элссэн. 894.8 тэрбум төгрөгийн зээлд 2024–2026 онд 147.4 тэрбум төгрөгийн хүүгийн татаас олгосон. Үржлийн мал авах зээлд хамрагдсан малчдын өрхийн орлого 34%-аар нэмэгдэж, 1,109 ажлын байр бий болсон гэж тайлагнав.

5. Иргэдийн санал

Хоёр өдрийн сонсголд нийт давхардсан тоогоор 40 гаруй иргэн биечлэн санал хэлж, малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөнгөлөлттэй зээл, бэлчээр ашиглалт, уул уурхайн нөлөөлөл, гамшгийн эрсдэл, малчдын залгамж халаа, хууль хоорондын уялдаа зэрэг асуудлаар байр сууриа илэрхийлэв. Гол санал, шаардлагыг сэдвээр нь нэгтгэв.

Боловсрол. Малчны нэг хүүхдийг зөвхөн заасан мэргэжлээр сургах нь хязгаарлалт болж байна; хүссэн мэргэжлээрээ суралцах боломжийг хангахыг хүссэн (М.Бямбаахүү, Ё.Цэдэвсүрэн). 6 настай хүүхэд сургуульд элсдэг болсноор залуу малчид гэр бүлээрээ хоёр хуваагдаж, хөдөө эзгүйрч байна; 6, 7 настай хүүхдийг гэр бүлд нь хувилбарт сургалтаар сургах, хаврын амралтыг сар болгох (О.Отгонцэрэн). Малчдын боловсрол нь танхимын бус уламжлалт мэдлэг тул 6 дугаар зүйлд цаг уур шинжих, мал маллах уламжлалт арга, өв соёлыг эзэмшүүлэх заалт нэмэх (Г.Алтанхуяг судлаач).

Эрх-үүргийн тэнцвэр. Хуульд малчны үүргийг олон зааж, эрхийг хамгаалсан заалт дулимаг байна; 5 дугаар зүйлд хүний эрхийг дээдлэх, бэлчээр, ус, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, уул уурхайн сөрөг нөлөөнөөс хамгаалах зарчмыг нэмэх (В.Оюундэлгэр). Малчин амиа алдахад 50%, цагдаа/онцгойн албан хаагч амиа алдахад илүү үнэлгээ тооцдог нь шударга бус (Ц.Ундармаа).

Малчны тодорхойлолт ба эрх зүйн байдал. Малчин гэдэг тодорхойлолтыг (хуулийн 3.1.3) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд бус Малчны тухай хуульд тусгай заах; малчин бол 24 цаг, 365 өдрийн ажилтай, соёлын өвийг тээгч (Ч.Саранмандах). Хууль нь “халамжийн” бус “малчны эрх зүйн байдлыг баталгаажуулсан” хууль байх ёстой, нэмэлт өөрчлөлт оруулах (Н.Баярсайхан — “Хил хязгааргүй алхам” ТББ).

Уул уурхай, бэлчээр, газар. Говийн бүсийн малчдын өвөлжөө, хаваржаа уул уурхайн лицензтэй давхцаж, бэлчээр, ус хомсдож байна; малчдыг газартаа эзэн биш болгож байна (Ц.Бийбат, Ц.Баянмөнх, М.Бямбаахүү). Малчны тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Усны тухай хууль, Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн уялдааг хангах; уул уурхайн нөлөөллийн бүсийн малчдад нөхөн төлбөр тооцох (Ц.Бээжин, Ц.Ундрэм).

Нийгмийн даатгал. Малчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх заалтыг (4.2.9) яаралтай хэрэгжүүлэх нь хамгийн их давтагдсан шаардлага байв (Д.Гомбо-Очир, М.Сосоржав, Г.Мөнхбат, зэрэг малчид болон бичгээр ирүүлсэн санал).

Жендэр, эрүүл мэнд, гамшиг. Малчин эмэгтэйчүүдэд зориулсан тусдаа зээлийн бүтээгдэхүүн гаргах (Ш.Ариунаа). Хөдөөгийн эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжгүй, нарийн мэргэжлийн эмч, тоног төхөөрөмж дутагдалтай (Б.Юмжирмаа, зэрэг малчид). Онцгой байдлын нэгжгүй суманд хүчин чадал сайтай трактор шийдэх; гамшгийн өвс тэжээлийн нөөцийг урьдчилан бүрдүүлэх (О.Отгонцэрэн, Ц.Бийбат).

Нийтлэг санал: Хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох. Ялангуяа малчны эрх зүйн байдлыг тодорхойлсон, мал аж ахуйн салбарыг шууд зохицуулсан болон хамаарч байдаг бусад хууль тогтоомжтой уялдуулах шаардлагатай.

Бичгээр ирүүлсэн санал

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.7-д заасны дагуу урьдчилан бичгээр ирүүлсэн саналуудыг сонсгол даргалагч уншиж танилцуулан тэмдэглэлд тусгав. Үүнд: Говь-Алтай аймгийн Бугат сумын малчдын төлөөлөл (8 хүн) болон Дундговь, Завхан, Хөвсгөл аймгийн малчдаас тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэхийг шаардсан санал; Увс аймгийн малчнаас малчин, тариаланч залуусыг цэргийн албанаас чөлөөлөх санал; ШУ-ны гавьяат зүтгэлтэн, профессор Я.Ганболдын газрын эрх, бэлчээрийн даац, малын эрүүл мэндийн даатгал, малчны хөдөлмөрийн үнэлэмж зэрэг 10 чиглэлийн дэлгэрэнгүй санал багтав.

Саналыг дараах байдлаар багцалсан:

1. Малчны тухай хуулийн НДШ-ийг нэг удаа нөхөн төлүүлэх зохицуулалтыг яаралтай хэрэгжүүлэх;
2. Бэлчээр ашиглалт, хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
3. Мал эмнэлгийн үйлчилгээ, хүний нөөцийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
4. Малчдын орлогыг тогтворжуулах, үйлдвэрлэл эрхлэх боломжийг өргөжүүлэх;
5. Залуу малчдыг дэмжих, хүний нөөцийн бодлогыг шинэчлэх;
6. Малыг индексжүүлсэн даатгалыг малчдад өгөөжтэй болгож сайжруулах;

7. Малчдад чиглэсэн сургалт, мэдээлэл, зөвлөх үйлчилгээний тогтолцоог сайжруулах.

Дээрх саналууд нь Малчны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, малчдын эрх ашиг, нийгмийн хамгааллыг хангах, мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн гэж үзсэн саналууд байв.

6. УИХ-ын гишүүдийн асуулт, хариулт

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын гишүүд илтгэл бүртэй холбогдуулан холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнаас асуулт асууж, хариулт авч, үг хэлэв.

Асуулт-хариултын нэгдсэн статистик

Үзүүлэлт	1 дэх өдөр	2 дахь өдөр	Нийт
Асуулт асууж, үг хэлсэн УИХ-ын гишүүн	10	11	16 (ялгаатай)
Гишүүдийн асуулт/тодруулга/үг хэлэх удаа	54	49	103
Хариулт өгсөн төрийн байгууллага, албан тушаалтан	13 орчим	14 орчим	20 гаруй
Албан тушаалтны хариулт/илтгэлийн удаа	45	52	97

Тайлбар: дээрх статистик мэдээллийг дэлгэрэнгүй тэмдэглэлээс үндэслэсэн бөгөөд асуулт, тодруулга, үг хэлснийг хамтад нь багтаасан болно.

Асуулт асууж, үг хэлсэн УИХ-ын гишүүд

Эхний өдөр (06.23) — 10 гишүүн: Б.Уянга, С.Замира, П.Батчимэг, Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, О.Амгаланбаатар, М.Мандхай, Д.Жаргалсайхан, Х.Баасанжаргал, Г.Тэмүүлэн.

Хоёр дахь өдөр (06.24) — 11 гишүүн: М.Ганхүлэг, Ц.Мөнхбат, Г.Тэмүүлэн, Г.Ганбаатар, О.Алтангэрэл, Х.Баасанжаргал, Ц.Туваан, Б.Бейсен, Л.Мөнхбаясгалан, Д.Жаргалсайхан, Р.Сэддорж.

Хоёр өдрийн нийлбэрээр асуулт асууж, үг хэлсэн ялгаатай 16 УИХ-ын гишүүн: Б.Уянга, С.Замира, П.Батчимэг, Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, О.Амгаланбаатар, М.Мандхай, Д.Жаргалсайхан, Х.Баасанжаргал, Г.Тэмүүлэн, М.Ганхүлэг, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, О.Алтангэрэл, Ц.Туваан, Б.Бейсен.

Хариулт өгсөн төрийн байгууллага, албан тушаалтан

Эхний өдөр: Боловсролын яамны ТНБД Т.Ням-Очир, ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Сангийн яамны ТНБД Б.Анар, ГЗБГЗЗЕГ-ын дарга А.Энхманлай, ЦХИХХЯ-ны ТНБД Б.Мягмарнаран, ЭМЯ-ны ЭМД-ын газрын дарга Д.Отгонбаатар, ЭМЯ-ны ТНБД Н.Эрдэнэбаяр, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Х.Алтангэрэл, ХААИС-ийн проректор А.Буянбаатар, ГБХНХЯ-ны Нийгмийн

даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Б.Рэнцэнханд, мөн хууль санаачлагч УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, судлаач О.Энххүслэн.

Хоёр дахь өдөр: Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, ХХААХҮ-ийн сайд Ц.Идэрбат, ГБХНХ-ын сайд Т.Аубакир, ГБХНХЯ-ны ТНБД А.Даваажаргал, ОБЕГ-ын дарга Г.Ариунбуян болон тэргүүн дэд дарга Ц.Ганзориг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Шадар сайдын ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил, Шадар сайдын ажлын албаны Шинэ хоршоо хариуцсан шинжээч Б.Болд, ХААИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга Л.Уранбилэг, ХХААХҮЯ-ны Мал аж ахуй, генетик нөөцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Чой-Иш, ГБХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Гэр бүлийн бодлогын газрын ахлах шинжээч М.Цогтбаатар, ГЗБГЗЗЕГ-ын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр.

Гол асуулт, хариултууд

- Хэдэн журам гарах ёстойгоос хэд нь батлагдсан, хэзээ батлагдах вэ — ХХААХҮЯ, Сангийн яам хариулсан (нийт ≈11 журмаас 2 нь батлагдаагүй).
- Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх заалт яагаад хэрэгжихгүй байна — ГБХНХЯ, Сангийн яам: 5 жилд 375.5 тэрбум төгрөг шаардлагатай, бусад яам дэмжээгүй, журам батлагдаагүй, хуулийн хугацаа 2026.01.01-нд дууссан.
- Малыг хөрөнгөөр үнэлэх, зах зээлийн ханшид суурилсан хөрөнгийн үнэлгээ хийх (9.7) — Монголбанк, Сангийн яам: журам боловсруулагдаж байна.
- Зээлийн өндөр хүүг бууруулах боломж — Монголбанк: даатгал, цахимжуулах, төрийн татаастай хөтөлбөрөөр буурах боломжтой.
- Малчны хүүхдийг сургах мэргэжлийн хүрээ (мал эмнэлэг, зоотехник орохгүй) — Боловсролын яам, ХААИС: хууль, журамд өөрчлөлт оруулж байж шийдэгдэнэ.
- Эрүүл мэндийн даатгалын хамрагдалт 40%-д хүрэхгүй, эрт илрүүлэг зогссон — ЭМЯ: шинэчилсэн журам, бодлогын арга хэмжээ.
- Уул уурхайн лицензтэй давхацсан өвөлжөө, хаваржааны газар — Газар зохион байгуулалтын ерөнхий газар: 2024 оноос давхцал гаргуулахгүй дүгнэлт гаргаж олгож байна.

7. Гишүүдийн байр суурь

Хоёр өдрийн сонсголын үеэр Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, санал, байр суурийг нэгтгэн үзэхэд дараах нийтлэг асуудлууд байна. Үүнд:

- **Малчны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, хууль дээдлэх зарчим алдагдаж байгааг** гишүүд онцлон тэмдэглэв. УИХ-аас баталсан хуулийг Засгийн газар бүрэн хэрэгжүүлэх Үндсэн хуулийн үүрэгтэй бөгөөд хуульд заасан журам, зохицуулалтыг хугацаанд нь батлаагүй нь иргэдийн эрхийг хязгаарлаж, хууль хэрэгжих боломжийг алдагдуулсан талаар; (УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, Л.Мөнхбаясгалан)

- **Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн механизм хэрэгжих шаардлагатай** гэж үзэж, хууль хэрэгжүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан, хугацаа алдсан байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох, шаардлагатай тохиолдолд Үндсэн хуулийн цэцээр эрх зүйн маргаан шийдвэрлүүлэх асуудлыг хөндөх талаар; (УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, Г.Ганбаатар, О.Алтангэрэл)
- **Сонсголд салбарын сайд нарын хангалтгүй байгаа талаар болон хууль хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн салбарын сайд нар өөрсдөө сонсголд оролцож тайлбар өгөх ёстой боловч яамны ТНБД, газрын дарга нар хариулт өгч байгаа нь парламентын хяналтын ач холбогдлыг бууруулж байгаа талаар;** (УИХ-ын гишүүн Д.Жаргалсайхан, Л.Мөнхбаясгалан, М.Мандхай)
- **Мал аж ахуйн салбарын бодлого, статистик мэдээллийн чанар, салбар хоорондын уялдаа хангалтгүй байгааг онцолж, бодит нөхцөл байдлыг үнэн зөв тусгасан мэдээлэл, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах шаардлагатай талаар;** (УИХ-ын гишүүн М.Мандхай)
- **Мал аж ахуйг тооноос чанарт шилжүүлэх бодлого хэрэгтэй бөгөөд малыг хөрөнгө гэж үнэлэх, малчны хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, бүтээмжид суурилсан эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх шаардлагатай талаар;** (УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, Ц.Туваан)
- **Малчдын санхүүгийн үйлчилгээний нөхцөлийг сайжруулж, зээлийн хүүг бууруулах асуудлыг хөндөж, төлбөрийн сахилга бат өндөртэй малчдад эрсдэлийн үнэлгээнд суурилсан ялгавартай нөхцөлөөр зээл олгох, даатгал, төлбөрийн түүх зэрэг шалгуурыг ашиглах боломжийг судлах шаардлагатай талаар;** (УИХ-ын гишүүн М.Ганхүлэг, Х.Баасанжаргал, Ц.Туваан)
- **Мал аж ахуйн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, залгамж халааг дэмжих бодлого шаардлагатайг онцолж, малын гаралтай бүтээгдэхүүний үнэ цэнийг өсгөх, махны зах зээлийг тогтворжуулах нь залуу үеийг мал аж ахуйд үлдэх нөхцөл болохыг тэмдэглэв. Мөн малчны хүүхдийг малчин болохыг дэмжих эдийн засаг, нийгмийн хөшүүргийг бий болгох талаар;** (УИХ-ын гишүүн Ц.Туваан, Ц.Мөнхбат)
- **Малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах шаардлагатайг онцолж, Малчны тухай хуульд туссан нийгмийн даатгалын шимтгэлийн нэг удаагийн нөхөн төлөлтийн зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх, малчны хүүхдийн дотуур байрны орчин, хамгааллыг сайжруулах, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар;** (УИХ-ын гишүүн Р.Сэддорж, Х.Баасанжаргал, Б.Бейсен)
- **Хууль батлахдаа төсөв, санхүүгийн бодит боломжийг урьдчилан тооцох шаардлагатайг онцолж, санхүүгийн эх үүсвэргүйгээр хууль батлах нь хуулийн хэрэгжилтийг сааруулж, иргэдийн хүлээлтийг биелүүлэх боломжгүй нөхцөл үүсдэг талаар;** (УИХ-ын гишүүн Г.Ганбаатар, О.Алтангэрэл).

Нийтлэг байдлаар: Оролцогчдын хувьд Малчны тухай хуулийг боловсронгуй болгох, Ашигт малтмалын тухай, Газрын тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжтой уялдуулах талаарх саналыг гаргасан бол Улсын Их Хурлын гишүүдийн хувьд одоо хэрэгжиж байгаа хуулийн агуулгыг өөрчлөхөөс илүүтэйгээр хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилтийг хангаагүй төрийн байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох,

цаашид хэрэгжих боломжгүй болсон зохицуулалтыг шинэчлэх зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай талаар байр сууриа илэрхийлсэн болно.

8. Сонсгол даргалагчийн дүгнэлт

- Хяналтын сонсголын зорилго нь бодит мэдээлэл цуглуулах, төрийн байгууллага, иргэдийн байр суурийг сонсох, иргэдийн мэдэх эрхийг хангах бөгөөд сонсголоос шууд шийдвэр гаргахгүй, харин гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох байгууллагад чиглэл өгөхөд оршино.
- Засгийн газар, сайд нар Улсын Их Хурлаас баталсан хуулийг бүрэн хэрэгжүүлэх Үндсэн хуулийн үүрэгтэй бөгөөд тангараг өргөсөн албан тушаалтны хувьд сонсголд биечлэн оролцож, хуулийн хэрэгжилтийн талаар бодит тайлбар, хариулт өгөх ёстой. Хэрэв хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн бол холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх нь Засгийн газрын бүрэн эрхийн асуудал болохыг онцлон тэмдэглэв.
- Улсын Их Хурлын парламентын хяналтын үндсэн зорилго нь төрийн байгууллагуудаас хариуцлага шаардах, хууль хэрэгжихгүй байгаа шалтгаан, хариуцлага алдагдсан нөхцөл байдлыг тогтоож, цаашид хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн бодит арга хэмжээний үндэслэл бүрдүүлэхэд оршино гэж үзэв.
- Малчны тухай хуулийн хэрэгжилтийг үр дүнтэй хангахын тулд бэлчээрийн асуудлыг бие даасан эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэх шаардлагатайг онцолж, Бэлчээрийн тухай хуулийг батлан хэрэгжүүлэх, мөн сонсголын үеэр малчид, иргэд, судлаачдаас гарсан саналыг тусган Малчны тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэв.

9. Нэгдсэн дүгнэлт

Хоёр өдрийн сонсголын мэдээлэл, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, төрийн байгууллага, албан тушаалтны тайлбар, танилцуулга, иргэдийн санал, УИХ-ын гишүүдийн асуултад үндэслэн дараах дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

1. Малчны тухай хууль батлагдсанаас хойш жил гаруй хугацаа өнгөрсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Хуульд заасан зарим чухал хэрэгжүүлэхээр заасан арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, журам батлагдаагүй, салбар дундын ажлын уялдаа хангалтгүй, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих тогтолцоо сул байна.
2. Малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, залгамж халааг бэлтгэх арга хэмжээний эрх зүйн зохицуулалтууд бодит үр дүнд хүрээгүй. Ялангуяа малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх зохицуулалт, малчны хөгжлийг дэмжих зарим арга хэмжээ хэрэгжээгүй байна.
3. Малчдын өмнө тулгамдсан хамгийн том асуудал нь бэлчээр, газрын харилцаа, уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөл хэвээр байна. Малчдын бэлчээр ашиглах эрх, өвөлжөө, хаваржааны хамгаалалт, усны нөөцийн ашиглалттай холбоотой зохицуулалтыг бусад хууль тогтоомжтой уялдуулах шаардлагатай байна.

4. Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үнэлэмж, малчдын санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна. Малчид хамгийн сахилга баттай зээлдэгч хэдий ч өндөр хүүтэй зээл авч байгаа нь хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт, ипотека, даатгалын тогтолцооны хүртээмж сул байгааг харуулж байна.
5. Малчны тухай хууль нь зөвхөн нэг салбарын бус, Монгол Улсын үндэс, хүнсний аюулгүй байдал, үндэсний уламжлалт мал аж ахуй, хөдөөгийн хөгжлийн суурь асуудлыг зохицуулсан бодлогын ач холбогдолтой хууль болохыг онцлон тэмдэглэв.

10. Цаашид авах арга хэмжээний санал

Сонсголын нэгдсэн дүгнэлтэд үндэслэн цаашид дараах арга хэмжээ авахыг шаардлагатай байна. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

1.1. Малчны тухай хуулийн хэрэгжилтийн явцад илэрсэн хүндрэл, эрх зүйн хийдэлд үндэслэн нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлах.

1.2. Малчны тухай хуулийг Газрын тухай, Ашигт малтмалын тухай, Усны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Малын генетик нөөцийн тухай, Хөдөө аж ахуйн тухай хуулиудтай уялдуулах асуудлыг судалж шийдвэрлэх.

1.3. Малчны тухай хуульд заасан боловч өнөөдрийг хүртэл батлагдаагүй дүрэм, журам, аргачлал, төлөвлөгөөг яаралтай баталж мөрдүүлэх, шаардлагатай тохиолдолд хуулийн хугацаатай зохицуулалтыг шинэчлэн шийдвэрлэх. Эдгээр нь сонсголын үр дүнгээс гарсан хамгийн гол дүгнэлт юм.

2. Малчны эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр:

2.1. Малчны зээлийн бодлогыг шинэчилж эрсдэлд суурилсан хүү, төлбөрийн түүх, индексжүүлсэн даатгал, тогтвортой худалдан авагчтай эсэх зэрэг шалгуур үзүүлэлтийг ашиглах боломжийг судлах.

2.2. Малчны хөрөнгийн үнэлгээний тогтолцоо, хөрөнгийн үнэлгээний аргачлалыг боловсруулж мөрдүүлэх.

3. Малчны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр:

3.1. Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэг удаагийн нөхөн төлөлтийн асуудлыг эрх зүйн хүрээнд шийдвэрлэх.

3.2. Малчдын эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхдийн дотуур байр, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх салбар дундын уялдааг хангаж, арга хэмжээг эрчимжүүлэх.

3.3. Малчны хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

4. Бусад асуудлаар:

Ажлын хэсгээс Ерөнхий хяналтын сонголын тайлан, дүгнэлтэд үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцүүлэхийг санал болгож байна.

1. Ерөнхий хяналтын сонголын тайлан, дүгнэлтийг хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах.
2. Малчны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар Засгийн газар болон холбогдох байгууллагад чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж хэлэлцүүлэх.
3. Сонголын явцад илэрсэн эрх зүйн хийдэл, салбар хоорондын уялдааны асуудлыг судлан, Малчны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар Байнгын хорооны санал, дүгнэлт боловсруулах.
4. Тогтоолын хэрэгжилтийн тайланг Засгийн газраас 2027 оны II улиралд Байнгын хороонд танилцуулахыг үүрэг болгох.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.БЕЙСЕН